

# ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНКНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН БОДЛОГО

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Тээвэр хөгжлийн банк (Цаашид “Банк” гэх)-ны Байгаль Орчин, Нийгмийн Бодлого (Цаашид “БОНБ” гэх)-ын үндсэн зорилго нь Монгол Улсын Тогтвортой Санхүүжилтийн Хөтөлбөрийн (Цаашид “ТоС” гэх) хүрээнд банкны үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн талаар баримтлах үндсэн зарчмууд, банкны хүлээх байгаль орчин, нийгмийн эрсдлийн хэм хэмжээ, хяналтын тогтолцоог тодорхойлоход оршино.

1.2. Банк нь дотоод үйл ажиллагаандаа байгаль орчин, нийгмийн хариуцлагын бодлогыг хэрэгжүүлж ажиллах ба зээлдэгчийн бизнесийн үйл ажиллагаанд байгаль орчин болон нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээг тухай бүр гаргаж, харилцагчид, цаашлаад банкинд үүсэх байгаль орчин, нийгмийн эрсдлийг бүүруулахаас гадна харилцагчийн байгаль орчин, нийгэмд ээлтэй бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн хүртээмжийг дэмжиж ажиллана.

1.3. Энэхүү бодлогод хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

1.3.1. “Монгол Улсын Тогтвортой Санхүүжилтийн Хөтөлбөр” гэж Монгол Улсын Банк, санхүүгийн системд зохистой санхүүжилтийн үзэл баримтлал, тогтолцоог нэвтрүүлэх зорилго бүхий Монголын Банкны холбоо болон Банкуудын хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсын нийгэм, байгаль орчинд ээлтэй тогтвортой санхүүжилтийн хөтөлбөр”-ийг;

1.3.2. “Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээ” гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээний явцад хүн амын эрүүл мэнд, байгаль орчин болон хуулиар хамгаалагдсан аливаа эрхэд үзүүлж болзошгүй зүй бус нөлөөллийг урьдчилан тодорхойлж, түүнийг багасгах, арилгах арга хэмжээ тогтоохыг;

1.3.3. “Санхүүгийн хүртээмж” гэж санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хувь хүн, өрх, бүлгээрээ зохистой хэмжээнд авах боломжийг;

1.3.4. “Ногоон эдийн засаг” гэж хүрээлэн буй орчны эрсдлийг бүүруулах, байгалийн нөөцийг үр ашигтай зарцуулах, экосистемийн тэнцвэртэй байдлыг хадгалах замаар тогтвортой хөгжилд хүрэх зорилго бүхий эдийн засгийн хөгжлийн загварыг;

1.3.5. “Байгаль орчин, нийгмийн эрсдэл” гэж зээл хүсэгчийн хүсч буй зээлтэй холбоотойгоор бизнесийн болоод эрсдлийн удирдлагын шийдвэр гаргахад анхаарах шаардлагатай эрсдэлд өртөж болзошгүй байгаль орчин, нийгмийн асуудлуудыг тус тус ойлгоно;

## ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ, ҮНДСЭН ЗАРЧМУУД

2.1. Банк нь Монгол улсын “Тогтвортой санхүүжилтийн хөтөлбөр”-т тусгагдсан 8 зарчмыг үндэслэн боловсруулсан бодлогын бичиг баримтын хүрээнд гаргасан санал санаачилгыг дэмжин, эдгээртэй холбоотой зохион байгуулагдах нэгдсэн арга хэмжээнүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлэн, Банкны бизнесийн болон дотоодын үйл ажиллагаанд удирдлага болгон ажиллана.

2.2. Банкны байгаль орчин, нийгмийн бодлого, журмаар дамжуулан өөрийн Банкны нийт ажилтан, харилцагч үйлчлүүлэгч, хамтран ажиллагч байгууллагууддаа хүрээлэн буй орчин, нийгэмд ээлтэй үйл ажиллагааны талаарх мэдлэгийг түгээж ажиллана.

2.3. Зээлдэгчийн бизнесийн үйл ажиллагааны Байгаль орчин, нийгмийн нөлөөллийг харгалзан үзэж, эрсдлийн үнэлгээг үндэслэн зээлийн шийдвэр гаргана. ТоС хөтөлбөрийн хүрээнд гаргасан “Санхүүжүүлэхийг хориглосон үйл ажиллагаа” болон “Анхаарах үйл ажиллагаа” жагсаалтад багтсан үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй.

2.4. Монгол Улсын “Тогтвортой санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд боловсруулсан дараах 8 зарчмыг Банкны бизнесийн болон дотоодын үйл ажиллагаанд удирдлага болгон ажиллана. Үүнд:

2.4.1. Байгаль орчноо хамгаалах: Банк нь хөрс ус, агаар, биологийн олон янз байдал, байгалийн сэргээгдэх болон сэргээгдэхгүй, шавхагдаж буй нөөцийг хадгалан хамгаалж, тэдгээрт үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байхаар тогтвортой ашиглах хандлагыг дэмжин ажиллана.

2.4.2. Хүний эрх, нийгмийн хамгаалал: Банк нь хүний эрхийг хүндэтгэж, хөдөлмөрийн аюулгүй байдлын стандартыг мөрдөнө. Иргэдийн эрүүл мэндийг хамгаалж, тэдгээрийн аюулгүй байдлыг ханган ажиллана.

2.4.3. Соёлын өвийг хамгаалах: Банк нь Монгол Улсын түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлөх соёлын онцгой өв болох ёс заншил, хэл, бусад өв, түүнчлэн соёл, түүх, археологи, палентологийн түүх соёлын дурсгалыг хадгалж хамгаалахад үйл ажиллагаагаа уялдуулж ажиллана.

2.4.4. “Ногоон эдийн засаг”-ийн өсөлтийг дэмжих: Банк нь Монгол Улсын ногоон, цэвэр эдийн засагт хувь нэмэр оруулах төсөл болон бусад үйл ажиллагааг дэмжин ажиллана.

2.4.5. Санхүүгийн хүтээмжийг дэмжих: Банк нь санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн, санхүүгийн боловсрол олгох, харилцагч хамгаалагдах баталгааг бий болгох замаар Монгол Улсад санхүүгийн өргөн хүрээтэй тогтолцоог бий болгоход хувь нэмрээ оруулж, холбогдох бодлого шийдвэрийг хэрэгжүүлж, дэмжин ажиллана.

2.4.6. Ёс зүйтэй санхүүжилт, компанийн засаглалыг дэмжих: Банк нь хориглосон жагсаалтанд багтсан үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй ба “Бид ёс суртахуунгүй, гэмт хэргийн шинж чанартай үйлдлийг үл тэвчинэ” гэсэн бодлогыг баримталж, ёс зүйтэй байх, компанийн засаглалтай холбоотой сайн туршлагуудыг дэмжих бодлого баримтлан ажиллана.

2.4.7. Ил тод байдал, хариуцлагыг дэмжих: Банк нь ил тод байдал, хариуцлагыг дэмжин, банкны тогтвортой санхүүжилтийн үүрэг хариуцлагын хүрээнд тайлагнах байдлыг дэмжин ажиллана.

2.4.8. Манлайлан үлгэрлэх: Банк нь харилцагчиддаа тавьж буй шаардлагыг өөрийн бизнесийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, Монгол Улсыг байгаль орчин, нийгмийн, эдийн засгийн хувьд эерэг хөгжилд чиглүүлэн ажиллахад өөрөөс хамаарах арга хэмжээг авч ажиллана.

2.5. Банк нь ОУСК-ийн Байгаль Орчин, Нийгмийн Тогтвортой байдлын гүйцэтгэлийн дараах 8 стандартыг үйл ажиллагаандаа мөрдөнө. Үүнд:

2.5.1. Гүйцэтгэлийн Стандарт 1: Байгаль орчин, нийгмийн эрсдэл ба нөлөөллийн үнэлгээ, менежмент

2.5.2. Гүйцэтгэлийн Стандарт 2: Ажиллах хүч ба ажлын байрны нөхцөл

2.5.3. Гүйцэтгэлийн Стандарт 3: Нөөцийг үр ашигтай зарцуулах ба бохирдлоос урьдчилан сэргийлэх

2.5.4. Гүйцэтгэлийн Стандарт 4: Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал

2.5.5. Гүйцэтгэлийн Стандарт 5: Газар чөлөөлөлт, албадан нүүлгэн суурьшуулалт

2.5.6. Гүйцэтгэлийн Стандарт 6: Биологийн олон янз байдлын хамгаалал, амьд байгалийн нөөцийн тогтвортой менежмент

2.5.7. Гүйцэтгэлийн Стандарт 7: Нутгийн уугуул иргэд

2.5.8. Гүйцэтгэлийн Стандарт 8: Соёлын өв

2.6. Банк нь дараах салбарт бизнесийн үйл ажиллагаа явуулж буй зээлдэгчийн тухайд харилцагчийн байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээг удирдамжийн дагуу эрсдлийг үнэлж холбогдох журмын дагуу ажиллана. Үүнд:

2.6.1. Уул уурхай

2.6.2. Барилга, дэд бүтэц

2.6.3. Хөдөө, аж ахуй

2.6.4. Боловсруулах үйлдвэр

## ГУРАВ. БАНКНЫ БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

3.1. Банк нь харилцагчаас шаардаж буй байгаль орчин, нийгмийн шаардлагыг дотоод үйл ажиллагаандаа үлгэрлэн хэрэгжүүлж, банкны үйл ажиллагааг ус, цаас, эрчим хүчний хэмнэлттэй явуулан, авилга, шударга бус өрсөлдөөн, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг үл тэвчих бодлогыг баримталж, ил тод тайлагнал, зохистой засаглал, ёс зүйтэй үйл ажиллагаа, эрх тэгш байдлыг эрхэмлэн ажиллана. Үүнд:

3.1.1. Цаасны хэрэглээ: Ашигласан цаасыг цуглуулж дахин боловсруулах, электрон шуудан зэрэг цаасгүй харилцааны аргуудыг өргөн хэрэглэх, цаасны 2 талд хэвлэх, харилцагчтай холбоотой гэрээ болон маягтын хуудасны тоог багасгах.

3.1.2. Эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээ: Дотоод үйл ажиллагаандаа эрчим хүчийг үр ашигтай хэрэглэхийг зорих, хэрэгцээгүй үед гэрэл болон цахилгаан хэрэгслүүдээ унтрааж, залгуураас салгаж хэвших.

3.1.3. Усны хэрэглээ: Усыг ариг гамтай хэрэглэх, усны алдагдлыг цаг алдалгүй засварлуулах.

3.1.4. Ногоон оффис: Боломжит салбаруудыг ногоон байгууламжтай болгох.

3.1.5. Хог хаягдлын менежмент: Хогийг ангилж хаядаг болох, үйл ажиллагааныхаа чиглэлийн хүрээнд хог хаягдлыг багасгах.

3.1.6. Аюулгүй ажиллагаа: Ажилтнуудаа аюулгүй ажлын орчинд ажиллуулах болон гэнэтийн ослын үед бэлтгэгдсэн байх тал дээр холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх.

3.2. Банк нь ажилтнуудыг “Ногоон санхүү”-гийн талаар сурч мэдэхийг дэмжих, байгаль орчин, нийгмийн хариуцлагын талаар чадавхийг дээшлүүлнэ.

3.3. Банк нь байгаль орчин, нийгмийн үнэлгээ хийх мэргэжлийн боловсон хүчин, мэргэжилтэн ажиллуулж тэдний хараат бус байдлыг хангаж, ажиллах орчин бүрдүүлж ажиллана.

## ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ЭРСДЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАГНАЛ, ХЯНАЛТЫН БОДЛОГО

4.1. Эрсдлийн удирдлагын газар /Цаашид “ЭУГ” гэх/ нь “Монгол улсын тогтвортой санхүүжилтийн зарчмууд”-ыг хэрэгжүүлэх ажлын явц, амжилт, тулгарч буй бэрхшээл, хоёрдмол асуудлуудын тухай мэдээллийг холбогдох газар хэлтсүүдээс нэгтгэн авч “ТоС-ийн

Удирдах хорооны тайлагналын маягт"-ын дагуу тайлан бэлтгэж банкуудын холбоонд хүргүүлж болно.

4.2. Байгаль орчин, нийгмийн нөлөөллөөс Банкны үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх дотоод хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх, тайлагнахад Банкны холбогдох газар, нэгжүүд батлагдсан чиг үүрийн хүрээнд тогтмол анхаарч ажиллана.

4.3. Банкны ажилтан Монгол улсын хууль тогтоомж, Монголбанк болон Банкны дүрэм, бодлого журам, заавар, гарын авлага, аргачлалын дагуу ажил үүргээ гүйцэтгэж, үнэнч шударгаар ажиллана. Мөн Банк нь хамт олны үнэт зүйл, эрхэм зорилт, ёс зүйн үндсэн зарчим, хэм хэмжээг хатуу баримтлана.

4.4. БОНБ-ын зээлийн үйл ажиллагаанд баримтлах бодлого, журамд тусгагдаагүй зээлтэй холбоотой асуудлыг Тээвэр хөгжлийн банкны зээлийн үйл ажиллагаатай холбоотой бодлого журмаар зохицуулагдана.

4.5. Байгаль орчин нийгмийн бодлогын хүрээнд Хавсралт №1-т тусгасан аливаа үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй ба цаашлаад Хавсралт №2-т тусгасан анхаарах үйл ажиллагааг санхүүжүүлэхдээ байгаль орчин, нийгмийн эрсдлийн судалгаа, дүгнэлтэд үндэслэсэн байна.

#### ТАВ. БУСАД

5.1. Байгаль орчин нийгмийн бодлогыг батлах, өөрчлөлт оруулах эрх нь Төлөөлөн удирдах зөвлөлд байна.

Тээвэр хөгжлийн банкны Байгаль орчин, Нийгмийн бодлогын Хавсралт № 1

### Санхүүжүүлэхийг хориглосон үйл ажиллагааны жагсаалт

1. Олон улсын гэрээ, конвенц болон Монгол Улсын хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актаар хориглосон хууль бус үйл ажиллагаа, үйлдвэрлэл болон худалдаа;
2. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх ургамлын тариалан болон хуулийн зохицуулалтгүй мансууруулах бодисын үйлдвэрлэл, тээвэрлэлт болон худалдаа;
3. Хууль бус мөрийтэй тоглоом, казино болон түүнтэй адилтгах үйл ажиллагаа;
4. Садар самуун явдлыг сурталчлах, дэмжих, зохион байгуулах үйл ажиллагаа;
5. Албадан хөдөлмөр эрхлэлт<sup>1</sup>, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр<sup>2</sup> ашигласан үйл ажиллагаа, ялгаварлан гадуурхал, хуульд заасан ажиллагсдын эвлэлдэн нэгдэх, хамтын хэлэлцээр байгуулах эрхийг хязгаарласан үйл ажиллагаа;
6. Галт зэвсгийн үйлдвэрлэл, худалдаа;
7. Согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаа (пиво, дарснаас бусад);
8. Тамхины үйлдвэрлэл, худалдаа<sup>3</sup>;
9. Олон шатлалтай маркетинг, пирамидын сүлжээгээр дамжуулан ашиг, орлого олох үйл ажиллагаа;
10. Экспорт, импорт болон дамжин өнгөрч буй орнуудаас авсан шаардлагатай импорт, экспортын гэрчилгээ, зөвшөөрөлгүй, эсвэл дамжин өнгөрүүлж тээвэрлэх зөвшөөрөлгүй барааг худалдаалах үйл ажиллагаа;
11. Олон улсын болон үндэсний хамгаалалттай газар нутагт үйл ажиллагаа явуулах;
12. Биологийн олон янз байдал, түүх, соёлын өвийг хамгаалахтай холбоотой Олон улсын конвенци, гэрээ болон Монгол улсын хуулийн дагуу хориглосон үйл ажиллагаа, Тухайлбал:
  - ЮНЕСКО-ийн Дэлхийн Өв Соёлыг Хамгаалах Сайт / <https://whc.unesco.org/> /
  - ЮНЕСКО-ийн Биомандалын Нөөц / <https://portal.unesco.org/science/> /
  - Рамсар Сайтын Олон Улсын Ач Холбогдол бүхий Намагшсан Газар, ялангуяа Усны Шувууд олноор амьдардаг орчин / <https://www.ramsar.org/> /

---

<sup>1</sup> Албадан хөдөлмөр эрхлэлт гэдэг нь хэн нэг этгээдийн заналхийлэл, хүч, шийтгэлийн дор сайн дураар бус хийж буй бүх ажил, үйлчилгээг хэлнэ.

<sup>2</sup> Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр гэдэг нь эдийн засгийн хувьд мөлжсөн, аюултай, хүүхдийн сурч боловсроход нь саад болох, хүүхдийн эрүүл мэнд, биеийн, оюун санааны, ёс зүйн болон нийгмийн хөгжилд хортой, аюултай байхыг хэлнэ.

<sup>3</sup> Эдгээр үйл ажиллагааг үндсэн үйл ажиллагаагаар болгоогүй компани хамаарахгүй буюу тус компанийн тухайн үйл ажиллагаанаас олох орлого нь нийт орлогын 10%-иас доош байх тохиолдолд хориглосон жагсаалтад хамаарахгүй болно.

13. Асбест<sup>4</sup> болон түүний нэгдлийг агуулсан нэгдлийг агуулсан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа болон ашиглалт;
14. Полифлорт бифенил<sup>5</sup> агуулсан аливаа бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон худалдаа;
15. Олон улсад хориглосон chlorofluorocarbons (CFCs), halons, бусад озоны давхарга задалдаг бодисууд<sup>6</sup> агуулсан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа болон ашиглалт;
16. Олон улсад хориглосон (Роттердам<sup>7</sup>, Стокгольмын конвенциор<sup>8</sup> хориглосон бусад бүх үйл ажиллагаа) хортон шавж үстгах пестицид, гербицид, эм зүйн бүтээгдэхүүн болон бусад хорт бодисын үйлдвэрлэл, худалдаа;
17. Байгалийн нэн ховордсон мөн CITES<sup>9</sup>-н конвенцид багтах зэрлэг амьтан, ургамлын төрөл зүйлийн худалдаа;
18. Байгаль орчинд сөрөг нөлөөтэй аргаар (тэсрэх бодис ашиглах болон 2.5 км-ээс урт хөвөгч тор ашиглах) загасчлах;
19. Олон улсад хориглосон хог хаягдлын тээвэрлэлт, үстгал;
20. Байгаль хамгааллын өндөр ач холбогдолтой ойн сан бүхий газраас мод бэлтгэх болон мод бэлтгэлийн үйл ажиллагаанд зориулагдсан тоног төхөөрөмжийн худалдаа;
21. Ойжуулалтын тогтвортой менежмент дор хөгжүүлж буй ойн бүсээс бусад газар мод, ойн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа;
22. Цацраг идэвхит бодис/материалын үйлдвэрлэл, худалдаа болон олборлолт<sup>10</sup>.

---

<sup>4</sup> Асбестийг бас шөрмөсөн чулуу гэх ба энэ нь байгаль дээр тархсан гидросиликат магни, төмөр, кальци, натригаас тогтсон маш нарийхан утсархаг бүтэцтэй, бутрамтгай чулуулаг эрдсүүд юм. Асбестийн нунтаг ширхэг нь агаарт нь агаарын бүлгийн эрдэс нь бат бэх, дулаан цахилгааныг бага дамжуулдаг, гадаад орчин, халуун, хүйтэн, галд болон химийн бодисын үйлчлэлд тэсвэртэй, удаан эдэлгээтэй зэрэг онцлог шинж чанаруудтай. Асбест агуулсан бүтээгдэхүүнийг барилгын материал, эрчим хүч, автомашины сэлбэг, дулаан тусгаарлагчийн үйлдвэрлэлд ашигладаг.

<sup>5</sup> Polychlorinated biphenyl (PCB) нь маш хортой химийн бодисын нэгдэл. Энэ нь 1950-1985 онд үйлдвэрлэгдсэн зарим цахилгаан трансформатор, конденсатор болон хуваарилах төхөөрөмжид агуулагдах нь элбэг.

<sup>6</sup> Озон задлагч бодисууд нь старсоферын озонтой урвалд орж, түүнийг задалж озоны цоорхойг үүсгэдэг химийн нэгдэл юм. Дараах зүйлүүдэд озон задалдаг бодис агуулагдсан байдаг. Үүнд: хөргөгч, хөлдөөгч, хөргүүр, эйр кондейшн, хөргөх лангуу зэрэг хөргөх тоног төхөөрөмж гэх мэт.

<sup>7</sup> Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмын конвенцийн жагсаалтын Хавсралт А хэсэгт дурдсанаар <https://www.legalinfo.mn/law/details/10707>

<sup>8</sup> Аюултай зарим химийн бодис болон пестицидийг ОУ хэмжээнд худалдаалахад хэрэглэх, урьдчилан мэдээлж зөвшилцөх журмын тухай Роттердамын конвенцийн тухай <https://www.legalinfo.mn/law/details/10706>

<sup>9</sup> Монгол улсаас энэ конвенцийн нэг, хоёрдугаар хавсралтад 14 зүйл хөхтөн, 71 зүйл шувуу, 8 зүйл ургамал, 2 зүйл загас, шавж, мөлхөгч, тус бүр нэг зүйл орсон юм. Дараах холбоосоор жагсаалтад орсон амьтдыг шалгах <http://checklist.cites.org/#>

<sup>10</sup> Үүнд Эмнэлгийн зориулалтын эмчилгээ, оношилгооны тоног төхөөрөмж, чанарын хяналтын (хэмжих) тоног төхөөрөмж хамаарахгүй.

### Анхаарах үйл ажиллагааны жагсаалт

1. Оршин суугчдыг албадан суурьшуулахад хүргэх аливаа үйл ажиллагаа;
2. Орон нутгийн иргэдийн амьжиргаанд чухал ач холбогдолтой газрын маргаантай аливаа үйл ажиллагаа, тусгай хамгаалалтын газартай ойролцоо явагдах аливаа үйл ажиллагаа, мөхөх аюулд ороод байгаа, нэн ховордсон төрөл зүйл, биологийн олон янз байдлын уугуул тархачын хүрээн дэх экологи, эдийн засгийн ач холбогдол бүхий газрыг хамруулсан аливаа үйл ажиллагаа;
3. Археологи, түүх, соёлын өвийг эвдэж, устгаж болзошгүй аливаа үйл ажиллагаа;
4. Хувиргасан амьд организмыг<sup>11</sup> худалдаалах, нутагшуулах;
5. Цөмийн энерги (хайгуул, олборлолт, ураны баяжуулалт, цөмийн түлшний хадгалалт, тээвэрлэлт, цөмийн энерги түгээлт, дамжуулалт);
6. Цацраг идэвхит хог хаягдлын хадгалалт, тээвэрлэлт;
7. Газрын тос, байгалийн хийн олборлолт, байгалийн хийн дамжуулах хоолойн барилгын ажил бүхий томоохон төслүүд;
8. Хар болон өнгөт металлын олборлолтын томоохон төслүүд;
9. Усан цахилгаан станци, дулааны станцийн барилгын ажил;
10. Ахуйн болон аюултай хог хаягдлын<sup>12</sup> устгал;
11. Хөдөлмөрийн нөхцөл, ажилчдын амьдралд ихээхэн сөрөг нөлөөлөл учруулах аливаа төсөл, нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөлөлтэй аливаа төсөл;
12. Тамхи, шар айраг, дарснаас бусад согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаа.

---

<sup>11</sup> Хувиргасан амьд организмын тухай хуулийн дагуу <https://www.legalinfo.mn/law/details/536>

<sup>12</sup> Хог хаягдлын тухай хуульд зааснаар аюултай хог хаягдал гэдэг нь тэсрэмтгий, шатамхай, урвалын идэвхтэй, исэлдүүлэгч, агаар болон устай харилцан үйлчилж хортой хий ялгаруулдаг, халдвартай, идэмхий, хүн амьтанд богино болон удаан хугацаанд хортой нөлөөлөл үзүүлдэг, байгаль орчинд хортой шинж чанартай, устсаны дараа аюултай шинж чанартай ялгарал үүсгэдэг хог хаягдал юм.